

srd

НААХЗГ-ны вебсайтад тавтай морилно уу

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын газар нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж үйл ажиллагаагаа явуулж байна

Иргэний нисэхийн үйл ажиллагааг шинээр эрхлэх байгууллага, хувь хүн болон иргэний нисэхэд ашиглах бүтээгдэхүүнд зөвшөөрөл өгч, тэдгээрийг гэрчилгээжүүлж, баталгаа олгох замаар эхний буюу анхдагч хяналтыг тавина.



Зайлшгүй шаардлагатай үзлэг шалгалтыг тогтмол хийх, хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх замаар аюулгүй ажиллагааны стандартуудыг мөрдүүлнэ.

Иргэний нисэхийн үнэмлэх, гэрчилгээ авахаар хүсэлт гаргагчийг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, мөн иргэний нисэхийн байгууллага, ажилтнуудад Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль, иргэний нисэхтэй холбогдолтой дүрмүүдийг дагаж мөрдөхөд нь дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

Иргэний нисэхийн хууль, дүрэм, журам зөрчигчдөд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд аюулгүй ажиллагааны ашиг сонирхлын үүднээс шаардлагатай гэж үзвэл иргэний нисэхийн бичиг баримт болох үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгоно.